



БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАРЫН ЗАЛУУ ЭРДЭМТДИЙН ХОЛБОО

2014 ОН 09 САР 18 ӨДӨР

ДУГААР 11

Улаанбаатар хот

ИХ, ДЭЭД СУРГУУЛИУД БОЛОН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН, ТӨВ, КОРПОРАЦИУДЫН ЗАХИРГААНД

Хурал зохион байгуулах тухай

БШУЯ, ШУА, ШУТС, Технологи Инкубаторын Төв, Монголын Залуу Эрдэмтдийн Холбоо, Байгалийн Ухааны Салбарын Залуу Эрдэмтдийн Холбоо хамтран жил бүр залуу судлаач, багш, эрдэм шинжилгээний ажилтнуудын дунд зохион явуулдаг “Хүрэл Тогоот 2014” эрдэм шинжилгээний бага хурал 2014 оны 10-р сарын 24-ний өдөр ШУА-ийн ООГСТ-ийн харьяа одон орон судлах “Оргил төв”-д болох тул өөрийн байгууллагын залуу ажилтнуудыг өргөнөөр оролцуулна уу.

Уг бага хуралд илтгэл тавин оролцсон залуучуудыг мэдлэг, чадвар, судалгааны ажлын үр дүнгээр нь шалгаруулан 35 хүртэлх насны докторын зэрэг хамгаалаагүй хоёр залуу судлаачид БШУ-ны сайдын залуу судлаачидад олгодог **ГРАНТ**-ыг (4 сая төгрөг) Байгалийн ухааны салбараас олгоно.

Энэхүү бага хуралд тавигдах илтгэлүүдийн хураангуйг буюу эрдэм шинжилгээний өгүүллийг 2014 оны 10-р сарын 10-ныг дуустал хүлээн авах тул залуу судлаач нар өөрсдийн бүтээлийг дараах тусгай форматын дагуу бэлдэж зохион байгуулах комисст заагдсан хугацаанаас өмнө дараах хаягаар илгээнэ үү. Уг хурлын талаар тодорхой мэдээллийг мөн доорхи хаягаар хандаж авна уу.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ОТГОНСУВД

Бүтээлд тавигдах шаардлага

1. Эрдэм шинжилгээний өгүүлэл (ЭШӨ) нь дараах хэсгүүдтэй байна.
 - Өгүүллийн нэр
 - Зохиогчийн овог нэр, электрон шуудангийн хаяг, утас
 - Өгүүллийн хураангуй (Монгол, Англи хэлээр бичигдсэн)
 - Түлхүүр үг
 - Судалгааны үндэслэл буюу оршил
 - Судалгааны арга зүй
 - Үр дүн
 - Хэлэлцүүлэг
 - Дүгнэлт
 - Ном зүй
2. ЭШӨ нь хураангуй, түлхүүр үг, оршил, текст, зураг (график болон фото зураг), хүснэгт, дүгнэлт, ишлэл татсан ном, зохиолын нэрс, зохиогчийн товч намтрыг оролцуулан 297x210мм (A4) хэмжээтэй 5 хүртэл хуудсанд багтаасан байна.
3. Өгүүллийг зөвхөн MSWord 2003–аас хойших хувилбараар *.doc буюу *.docx өргөтгөлтэй форматыг ашиглан Arial фонтоор бичнэ.
4. Өгүүллийг A4 хэмжээний цаасан дээр хуудасны дээд, доод талаас 3 см; баруун, зүүн талаас 2.5 см зайг үлдээж бичнэ. Өгүүллийг бичихдээ header, footer, footnote командыг ашиглахгүй. Мөн хуудасны дугаарыг тавихгүй.
5. Зүйл нь шинэ мөрнөөс, мөрний эхнээс эхлэх ба мөрүүд хоорондоо 1sp зайтай байна. Мөрүүд нь баруун, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
6. ЭШӨ-ийн хураангуйг 15 мөр, 200 үгэнд багтааж Монгол, Англи хэлээр бичнэ.
7. Өгүүлэлд 4-5 түлхүүр үг хэрэглэнэ. Өгүүллийн нэрэнд орсон үг түлхүүр үгэнд орохгүй. Түлхүүр үг нь нэр үг, нэрлэхийн тийн ялгал, ганц тоон дээр байна.
8. Бүх математик бичлэгүүд MS Equation, MathType, LaTeX програмаар бичигдэх бөгөөд ердийн математик бичиглэл 12pt өндөртэй байна. Томьёо нь дээд, доод талаасаа 12pt зайтай байх ба мөр голлон бичигдэнэ. Томьёоны дугаарыг тухайн мөрний төгсгөлд бага хаалтанд бичнэ.
9. График дүрслэл нь 2D зураглалтай байна. Хүснэгт, болон график дүрс нь хөндлөн зураасгүй байна.
10. Фото зураг, зураг, хүснэгт нь зөвхөн хар, цагаан өнгөтэй байна. Scanner ашиглаж оруулсан бүдүүвч зураг болон фото зураг нь 300 dpi нягтралшилтайгаар зургийн *.TIF, *.JPG, *.BMP, *.GIF өргөтгөлтэйгээр буулгагдаж текстэн дотор мөр голлон байрласан байна. Зураг дээрх үсэг, тооны өндөр нь ерөнхий текстийн үсэгний өндөртэй тэнцүү байх буюу 85%-иас бага байж болохгүй.
11. Ашигласан хэвлэлийн жагсаалт: VANCOUVER CITATION STYLE баримтлан бичнэ. Дараах холбоосоор хэвлэлийн жагсаалт бичих зааврыг харна уу. <http://www.ncbi.nlm.nih.gov/books/NBK7256/>
12. Нийтээр хэрэглэж заншаагүй товчилсон үгийг өгүүлэлд хэрэглэхгүй байвал зохино.
13. Зааврын дагуу бичигдсэн файлыг зарлагдсан албан тоотын дээрх электрон хаягаар холбогдох ажилтанд илгээнэ.
14. Зохион байгуулах комисс болон эрдэмтдийн зөвлөл нь шаардлага хангаагүй өгүүллийг буцаах, зохих хэмжээнд хүртэл товчлох эрхийг эдлэнэ.